



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/277

Арвайхээр сум

**Газар ашиглалтын зориулалтад  
өөрчлөлт оруулах тухай**

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 13 дугаар баг, Д.Пүрэвдорж-9 гудамж, 907 тоотод байрлах иргэн Ц.Алтансүх (ЙЮ74111673)-ийн эзэмшил худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалттай 739м<sup>2</sup> газрын зориулалтыг амины орон сууц, 13 дугаар баг, Д.Пүрэвдорж-2 гудамж, 211 тоотод байрлах иргэн Д.Түмэнгэрэл (ЙЮ70030727)-ийн эзэмшил худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалттай 1000м<sup>2</sup> газрын зориулалтыг 5-8 давхар нийтийн орон сууцны зориулалттай болгон өөрчлөлт оруулсугай.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0525

D:My Doc. Zahiramj. Zasag darga